

Валютын ханш, шатахууны үнэ тойрсон асуудлаар Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал С.Болдтой ярилцлаа.

Түлш шатахууны үнэ огцом өслөө. Үүнд чухам юу нөлөөлсөн гэж үзэж байна вэ?

Гол шалтгаан нь гадаад зах зээлийн хүчин зүйл юм. Тодруулбал түлш шатахууны үнэ гадаад зах зээлд өсч, импортын үнэ 2010 оны эхэн үеэс 57 хувиар, шатахууны төрлөөсөө хамаараад 53-70 хувиар өссөн байна.

Зарим хүмүүс валютын ханшнаас болсон гэж ойлгож байгаа. Валютын ханш чангарсан нь шатахууны үнэ өсөх шалтгаан болсон уу?

Төгрөгийн валюттай харьцах ханшийн сулралт нь газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниуд шатахууны үнийг дунджаар 16 хувиар буюу маш огцом өсгөх шалтгаан огт болоогүй. Үүнийг нотлох хэд хэдэн баримт хэлье. Судалгаанаас үзэхэд 2010 оны эхнээс өнөөг хүртэлх хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн индекс 3 хувиар чангарсан байхад дотоодын зах зээлд АИ92 маркийн шатахууны үнийн индекс 33 хувиар өссөн байх юм. Төгрөгийн ханш хоёр жилийн өмнөх түвшиндээ байхад түлш шатахууны үнэ нь шатахууны төрлөөсөө хамаараад хоёр жилийн өмнөхөөс 33-47 хувиар өсчихөөд байна шүүдээ.

Он гараад төгрөгийн ханш суларсан, бас шатахууны үнэ өссөн. Цаг хугацаа нь ингэж давхцаад байгаа болохоор хүмүүс үнийн өсөлтийг ханшаас болсон гэж бодоод байх шиг?

Шатахууны бизнес дунджаар 14 хоногийн мөчлөгтэй байдаг гэсэн тооцоо бий. Өөрөөр хэлбэл импортлосон шатахуунаа борлуулж дуусах, дахин импортоор авч борлуулах дундаж хугацаа 14 хоног. Шатахууны үнийг 14 хоногийн дотор 16 хувиар өсгөж байгааг бид сая харлаа. Гэтэл төгрөгийн ам.доллартай харьцах ханшид энэ хугацаанд 2 хувийн л өөрчлөлт гарсан. Иймд богино хугацаан дахь ханшийн хэлбэлзэл шатахууны үнийн огцом өсөлтийн шалтгаан болдоггүй гэдэг нь тодорхой байна.

Шатахууны үнийн өсөлт гадаад зах зээлийн шалтгаантай юм бол яагаад валютын ханшийн өсөлтөөс болсон, Монголбанк валют зараагүйгээс болсон гэж олон нийтийн дунд яриа үүсээд байгаа юм бэ?

Бид аливаа асуудлын учир шалтгааныг зөв танин мэдэх хэрэгтэй. Үндсэн шалтгааныг нь ололгүйгээр шийдэл ярих боломжгүй. Сүүлийн хэд хоногийг ажиж байхад шатахууны үнэ өссөн бодит шалтгааныг нийгэмд зөв тайлбарлаагүйгээс валютын дотоодын зах багагүй үймлээ. Энэ нь даамжирсаар бүр төрийн мөнгөний бодлогыг улстөржүүлэх, хараат бус байдалд нь сөргөөр нөлөөлж болзошгүй зохисгүй үйлдлүүд ч гарах болов. Энэ бүхэн эцсийн эцэст иргэдийн амьдралыг муутгах тогтворгүй байдал л үүсгэх аюултайг ойлгууштай.

Монголбанкнаас ханшийн талаар ямар бодлого баримталдаг юм бэ?

Монгол улс төгрөгийн валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтож байх маш тодорхой зарчмыг сүүлийн жилүүдэд баримталсаар ирлээ.

Цаашид ч уг зарчмыг тууштай баримтална. Валютын захад богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн хэт их зөрүү үүсч, тэр нь ханшийг огцом хэлбэлзүүлэх тохиолдолд Монголбанк тэрхүү огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад оролцож зохицуулдаг юм.

Төгрөгийн ханш валютын эсрэг суларч байгаа нь юутай холбоотой байна вэ?

Манай улс бүтээж байгаагаасаа илүүг хэрэглэдэг, үйлдвэрлэж чадаж байгаагаасаа илүүг зарцуулдаг хэвээр байна. Бодит чадавхиасаа давсан дотоодын хэрэглээг төсвийн хэт тэлэлт өдөөсөөр л байгаа. Нийлүүлэлтийн чадавхиас эрэлт нь даваад эхлэхээр эдийн засгаас импорт, үйлчилгээний төлбөр хэлбэрээр гарах валютын хэмжээ огцом өсч эхэлсэн. Статистик дурдахад өнгөрсөн онд валютын нийт орох урсгал жилийн 40 хувийн өсөлттэй байсан бол гарах урсгал 75 хувиар өссөн байна. Энэ нь валютын цэвэр урсгалын хэмжээ 2010 оноос 4 дахин буурахад нөлөөлсөн юм. Дээр нь гадаад худалдааны алдагдал 1.7 тэрбум ам.долларт хүрсэн гэдгийг дурдахад макро эдийн засгийн суурь нөхцөл өөрөө төгрөгийн валюттай харьцах ханш өнгөрсөн оны сүүлийн хагасаас эхлэн суларсны үндсэн шалтгаан нь болж байна.

Монголбанк хангалттай нөөцтэй байж доллар зараагүй. Тэр нь ханшийг сулрахад хүргэсэн гэж хүмүүс шүүмжилсэн. Энэ талаар?

Монголбанк ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр валютын захад шаардлагатай үед л оролцдог гэдгийг дахиад хэлье. Бид ханшийн түвшинг зорилт болгон барьдаггүй, зөвхөн ханшийн огцом хэлбэлзэлтэй тэмцдэг. Интервенц хийхийн тухайд Монголбанк өнгөрсөн оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн валютын захад оролцож, богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг зохицуулсан. Энэ хугацаанд нийт 300 гаруй сая ам.долларыг захад нийлүүлж, ханшийн огцом савлагаа үүсэхээс сэргийллээ. Өнгөрсөн хэд хоногт нийгмийн сэтгэлзүйд гарсан үймээн нь валютын дотоодын захад сөргөөр нөлөөлсөн. Ийм үед Монголбанк авах ёстой арга хэмжээгээ тасралтгүй хэрэгжүүлж, нийгэмд үнэн бодитой мэдээллийг өгсний үр дүнд ханшийн хөөрөгдөл арилж, энэ оны эхэнд байсан түвшинд очсон байна.

Валютын ханшийн өөрчлөлтийг бизнесүүд, хувь хүмүүс ер нь яаж зохицуулж удирдах вэ?

Ханшийн эрсдэлийг удирдахын тулд эрсдэлийг бууруулах санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашиглах хэрэгтэй байна. Монголбанк сүүлийн жил хагасын хугацаанд төгрөг ам.долларын, төгрөг юанийн своп хэлцлүүд хийх бүхий л боломжийг бүрдүүлж, банкууд, хувийн хэвшлийнхэнд удаа дараа сургалт зохион байгуулах, тэдэнд ач холбогдлыг нь ойлгуулах, бодитой хэлцлүүд хийх замаар валютын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь дэмжих зэрэг арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлсэн. Харамсалтай нь захад оролцогчид маань ханшийн эрсдэлээ удирдахад төдийлөн идэвх зүтгэл гаргахгүй, зах зээлд одоо байгаа хэрэгслүүдээ ашиглаж дадахгүй байна. Зүй нь эдгээр хэрэгслүүдээ идэвхтэй ашиглах ёстой бөгөөд ингэснээр ханшийн эрсдэлийг нийт системийн хэмжээнд бууруулах бололцоотой.